

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГАГ/2020/10-ГА

Ерөнхий боловсрол олгож буй бодлого зорилт, зорилго нь өнөөгийн нөхцөлд нийцэж байгаа ч зарим сургуулиудын хувьд мэргэжлийн боловсон хүчин дутмаг, стандарт бус дотуур байранд сурагчдыг байрлуулж байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёг.....	5-6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	7-8

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙГАА Ч ЗАРИМ ЕБС-ИУДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГА ҮҮСЭЖ БАЙНА.....9

А.1 Мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж ажилласан ч сургуулийн орчны байдал, сурагчдын дотуур байрны үйлчилгээнд тавигдах шаардлага, стандартыг өмнөх 3 жилд баталж ажиллаагүй байна. 9

А.1.1 Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм норматив хэрэгцээ шаардлагыг хангасан, харилцан уялдаатай байгаа ч зарим нэг хуулийн заалтууд хоорондоо зөрчигдөж байна.....9

А.1.2 Салбарын яамны бодлого хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж, харилцан уялдаатай байгаа ч орон нутгийн салбар нэгжээс багш болон мэргэжилтнээс хяналт шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулдаггүй байна.....10

А.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин, материаллаг орчин бүрдсэн ч зарим сургуулиудын хувьд дутмаг байна.....11

А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэн ажиллажээ..... 11

А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл зарим сургуулиуд дээр бүрэн бүрдээгүй байна.....12-15

А.2.3 Сургуулийн захирал, менежерүүд холбогдох шалгуурт нийцэж байгаа ч мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэврийн насны багш нарыг ажиллуулж байна.....16-17

А.3 Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг статистик мэдээний прогнозоор авч бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан боловч сүүлийн жилд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны олголт нормативт зардлаасаа илүү зарцуулсан байна. 177

А.3.1 Төсвийг нийт хүүхэд болон дотуур байр, 1-5 дугаар ангийн хүүхдийн статистик мэдээг үндэслэн төлөвлөж, хүүхдийн тоон үзүүлэлттэй холбогдуулан үр ашигтай хуваарилсан байна.17-19

А.3.2 Ерөнхий боловсролын сургуулийн жилийн төсөв дунджаар 18.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж тухайн төсвийн зарцуулалтад аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ажиллаж байна.....19-22

БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа ч багшийн цаг ашиглалт, орлон заах багшийн бүртгэл хангалтгүй байна..... 22

Б.1 Ерөнхий боловсролыг олгох хөтөлбөрт нийцсэн боловсрол олгож сургалтын чанарт үнэлгээ хийгдсэнээр үзэхэд 2018-2019 оны үзүүлэлт өмнөх оноос 8 байраар ахисан үзүүлэлт гарчээ. 22

Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу төлөвлөж байгаа ч багшийн нөөц боломжоос шалтгаалан хичээлийн хөтөлбөр цаг харилцан адилгүй төлөвлөгдөж байна.....22-23

Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарт үнэлгээг үнэлж дүгнэн ажилладаг ч нийт амжилтаас харахад сурлагын чанарын үнэлгээний хувь 2018-2019 онд өссөн үзүүлэлтэй байна.....23-24

Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг 16 сум 1 тосгоны хэмжээнд дотоод хяналтын баг томилж ажиллуулж байгаа боловч зарим сумын сургуулиудад хийгдсэн дотоод хяналт үр дүн муу байна. 24

Б.2.1 Салбарын яамны хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна.....24-26

Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллажээ. 26

Дүгнэлт:	27-28
ЗӨВЛӨМЖ:	28
Холбогдох санал:.....	29
Саналд өгсөн тайлбар:.....	30
ХАВСРАЛТУУД:.....	

Товчилсон үгийн тайлбар

ЗГ	Засгийн газар
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БСУГ	Боловсрол соёл ургийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЭШ	Элсэлтийн шалгалт
НХХС	Нийгмийн хөдөлмөр хамгааллын сайд
ММНББИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчийн институт

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сургуулиудын барилгын ашиглалтад орсон, өргөтгөл хийсэн сургуулийн барилга болон дотуур байрны барилгын он сар	12
Хүснэгт 2	Мэргэжил тохирохгүй багш ажиллуулж байгаа сургуулиуд	16
Хүснэгт 3	Ном сурах бичгийн тоон мэдээлэл	19
Хүснэгт 4	Дотуур байр, үдийн цайны хувьсах зардлын зөрчлүүд	20-21

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Дотуур байрны тасгийн тохижилтын зураг	13
Зураг 2	Кабинет ангийн зураг	14

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Он оны ЭШ-ын дүн болон үнэлгээний график	24
Дүрслэл 2	Эцэг эх, асран хамгаалалын хяналтын судалгааны гарфик	26

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	БСУГ-аас ирсэн саналын албан тоот	29
Хавсралт 2	Аймгийн ЗДТГ-аас ирсэн саналын албан тоот	29
Хавсралт 3	Гүйцэтгэлийн аудитын тушаал	30
Хавсралт 4	Гүйцэтгэлийн аудитын төлбөр зөрчлийн жагсаалт	31-32
Хавсралт 5	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн жагсаалт	33-34
Хавсралт 6	Төлбөрийн акт, албан шаардлагууд	35-43

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг БСШУСЯ, ЭМЯ, БХБЯ, ХНХЯ, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Барилгын хөгжлийн төв, аймаг, нийслэлийн ЗДТГ, хот байгуулалт, хөгжлийн асуудал, Газар зохион байгуулалт хариуцсан харьяа агентлаг байгууллагууд, Боловсролын газар, төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 6 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор Э.Уянга, Ж.Мөнхбилгүүн, Э.Мөнхмандах нар болон орон нутаг дах төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2019 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гүйцэтгэж, орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагуудаас аудитын тайлан, судалгааг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч нэгтгэх бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дотор Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Тус аудитыг хийхэд хөдөө сумдаар явах томилолт, шатахууны зардал шийдэгдэхгүйгээс шалтгаалж цаг хугацааны хувьд хүндрэлтэй, 100 хувь сургуулиудыг хамруулаагүй, гүйцэтгэлийн аудит хугацаандаа дуусгахаар илүү цагаар сунгаж ажилласан болно.

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙГАА Ч ЗАРИМ ЕБС-ИУДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГА ҮҮСЭЖ БАЙНА.

А.1 Мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж ажилласан ч сургуулийн орчны байдал, сурагчдын дотуур байрны үйлчилгээнд тавигдах шаардлага, стандартыг өмнөх 3 жилд баталж ажиллаагүй байна.

А.1.1 Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм норматив хэрэгцээ шаардлагыг хангасан, харилцан уялдаатай байгаа ч зарим нэг хуулийн заалтууд хоорондоо зөрчигдөж байна.

- Хуульд заасан дүрэм, журам, норм нормативыг баталсны дагуу баримтлан ажиллаж байна.

Боловсролын тухай хуульд зааснаар боловсролын байгууллагад мөрдөгдөх дүрэм, журам, норм нормативыг тухай бүр нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого боловсруулах зарчим хуульд үндэслэн Засгийн газрын тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал, бусад сайдын тушаал, шийдвэрээр холбогдох дүрэм журмыг тухай бүр нь шинэчилж мөн боловсролын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө нөөц санхүүгийн тогтолцоог хууль, журам, дүрэмд нийцүүлэн баталж ЕБС-иуд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллажээ.

Үүнд: Багшийн ажлын норм тогтоох, албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам, багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам, ЕБС-ын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал, цалингийн сүлжээ шинэчлэн тогтоох тухай тогтоол, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай тушаал, дүрэм журмыг хооронд нь уялдуулан баталсан ч зарим нэг хуулийн заалтууд хоорондоо зөрчигдөж байна.

Тухайлбал: Нийгмийн даатгалын тухай хуулиараа тэтгэвэрт тогтоолгох насанд хүрсэн багш нар боловсролын тухай хуулийн 43.1.4¹ дэх заалтад тусгагдсан ажилласан жил хүрэхгүй, тэтгэмжид хамрагдахгүй шалтгаанаар, төрийн албаны тухай хуулийн 46.3² дахь заалтад тусгагдсан төрийн жинхэнэ албан хаагч нь төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана гэсний дагуу тэтгэврээ тогтоолохгүйгээр ажлаа үргэлжлүүлэн хийж байгаа 10 гаруй багш байна.

- **Салбарын яам захиргааны хэм хэмжээний актад холбогдох салбар нэгжүүдээс санал авч ажиллажээ.**

Аймгийн хэмжээнд салбарын яаманд 2016-2019 оны хооронд ЕБС-ийн хичээлийн жилийн бүтэц, СӨБ-ын орчны стандартын төсөлд, "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-д, Багшийн ёс зүйн дүрэмд, Сурах бичгийн түрээсийн тогтолцоо-эргэлтийн санд, Багшлах эрх олгох хасах журам гэсэн нийт 6 саналын төсөлд санал хүргүүлж ажилласнаас тус журмуудын 3-5 санал нь дэмжигдсэн байна.

- **Мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, саналд тулгуурлан шинэчлэн баталж байгаа ч сургалтын хичээлийн хөтөлбөрийг жил бүр шинэчилж байна.**

Сүүлийн 3 жилийн байдлаар БСШУЯ нь аймаг, сумдын салбар нэгж болон ЕБС-ийн багш нараас шинэчлэгдэх журам дүрэм, тогтоолд санал авч хэрэгцээ шаардлагыг судалж үзэн шинэчилж боловсруулан ажилласан байна.

Үүнд: СӨБ-ын орчны стандарт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/812 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам", "Сурах бичгийн түрээсийн тогтолцоо-эргэлтийн сан", БСШУСайдын 2018

¹ "төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгах;"

² "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй".

оны А/762 тоот тушаалын хавсралтаар баталсан “ЕБС-д кабинет, лаборатори байгуулах ашиглах нийтлэг журам” зэрэг журамд өөрчлөлт оруулж мөрдөж ажиллаж байна.

Дээрх журам, дүрмээс гадна сургалтын хөтөлбөр цагийг жил бүр шинэчилж байгаа ч тухайн жилдээ 1-2 удаа өөрчлөгддөг, спортын дунд сургуулиудын хичээлийн цагийг багасгаж спортын хичээлийн цагийг нэмж өгч, суралцагчийн хүүхдийн тооноос хамаарч хичээлийн цагийн хөтөлбөрийг харилцан уялдаатай төлөвлөж гаргаагүй, сум тус бүрийн сургалтын хөтөлбөрийн цаг, хүний нөөц болон илүү цагийн тооцоолол харилцан адилгүй илэрхийлэгдэж багшийн цаг нормт цагаасаа их, багаар төлөвлөгдөн ажиллажээ.

Цаашид сургалтын хөтөлбөрийг тогтвортой, өөрчлөхгүй байх, сургуулийн төрлөөс хамаарч хичээлийн цагийг оновчтой төлөвлөж өгснөөр сургалтын чанар, үр өгөөж, үр дүнд нөлөө үзүүлж ахиц гарах магадлалтай байна.

Мөн багшийн цаг ашиглалтыг зөв зүйтэй удирдаж чөлөөтэй, өвчтэй, тасалсан багшийн оронд орсон багшид илүү цагийг бодож олгож байх, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах шаардлагатай байна.

- **Холбогдох дүрэм, журам, норм норматив, стандартыг бүрэн боловсруулж, баталсан ч сургуулийн аюулгүй байдал, сурагчдын дотуур байрны орчин үйлчилгээний тавигдах шаардлага стандартыг өмнөх 3 жилд баталж ажиллаагүй байна.**

ЕБС-иудын хүрээнд баримтлан ажиллах багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам, БШУСайд, НХХСайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан цэцэрлэг боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам, нэг суралцагчдад ногдох дундаж нормативыг тооцох, дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал, цалин хөлс нэмэгдлийг олгох тухай тогтоол, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах тушаал шийдвэр, стратеги төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж ажилласан ч ЕБС-ийн орчны аюулгүй байдал болон ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагын стандарт өмнөх жилүүдэд баталж ажиллаагүй, шинээр Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар баталж уг 2 стандартыг 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж эхэлжээ.

А.1.2 Салбарын яамны бодлого хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж, харилцан уялдаатай байгаа ч орон нутгийн салбар нэгжээс багш болон мэргэжилтнээс хяналт шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулдаггүй байна.

- ЕБС-ын бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, ерөнхий боловсролын чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайлан орон нутагт байхгүй байна.

ЕБС-ийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа ихэвчлэн их дээд сургуулиудын багш нарыг оролцуулдаг, хөдөө орон нутгийн нэгж салбар багш нараас татан оролцуулж санал авч ажилддаггүй гэсэн тайлбар өгч байна.

Хөдөө орон нутаг болон салбар нэгжээс хяналт шинжилгээ, судалгааны тайланд багш нар оролцуулж ажиллавал орон нутагт тулгамдаж байгаа асуудал, багш нарын хөтөлбөр цагийн уялдааг харгалзан үзэж ЕБС-ийн бодлого, хөтөлбөр нь үндэслэлтэй боловсруулагдана гэж үзэж байна.

- **Ерөнхий боловсролын талаарх бодлого хөтөлбөр харилцан уялдаатай ажиллаж хэрэгжилтийг ханган ажиллажээ.**

Аймгийн хэмжээнд нийт ЕБС-иуд боловсролын үйл ажиллагааг явуулж байгаа ч УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор, 2016 оны 70 дугаар тогтоолоор, 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан заалтуудтай, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлоготой /2014-2024 он/ уялдуулж Боловсролын яам жил бүрийн хичээлийн жилийн зорилт зорилго, бодлогыг тодорхойлсны үндсэн дээр, мөн аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн ИТХ-аар баталсан “Оюунлаг-Булган”, “Амжилтын галт тэрэг” зэрэг дэд хөтөлбөрүүдэд үндэслэн аймаг, сум, тосгоны ЕБС-иуд хичээлийн жил бүрийн зорилт, зорилго, бодлогоо уялдуулан боловсруулж батлуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээний 22 ЕБС-иас түүвэрлэлтийн аргаар 13 сургуулийг аудитад хамруулан шалгахад ерөнхий боловсролын сургуулиудын жил бүрийн баталсан зорилт, зорилго, бодлого нь УИХ, яам болон аймгаас баталсан бодлого төлөвлөлтэй уялдуулан боловсруулжээ.

Үүнд: ЕБС-иудын орчин нөхцөлийг сайжруулах, дотуур байрны тоог нэмэх, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, багшийн чадварыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг хангалтыг сайжруулах зэрэг бодлого төлөвлөлтийг тусгаж ажилласан нь бодлого төлөвлөлтийн гүйцэтгэлээр 2016-2017 оны хичээлийн жилд “Сурах бичиг түрээсийн тогтолцоо- Эргэлтийн сан” төсөл хэрэгжсэнээр 6-11 дүгээр ангийн нийт суралцагчид 77 хувьд хүрч аймгийн хэмжээнд 96.5 хувийн сурах бичгийн хангалттай үзүүлэлт гарсан байна.

Боловсрол соёл урлагийн газрын 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлангаас түүвэрлэхэд багш нарын хувьд мэргэжил боловсролоо дээшлүүлэх сургалтад жилд 1-2 удаа хамрагдаж давхардсан тоогоор төвлөрсөн, орон нутгийн, бүсийн ажлын байран дахь сургалтад нийт 2260 багш хамрагджээ.

Аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жилийн хичээлийн жилд “Уртын дуу-Морин хуур”, “Шатар”, “Мэтгэлцээн”, “Ой тогтоол” зэрэг хөтөлбөрүүд хэрэгжсэнээр нийт 27 гаруй төрлийн дугуйлан хичээллүүлж давхардсан тоогоор 7600 хүүхэд хамрагдсан байна.

A.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин, материаллаг орчин бүрдсэн ч зарим сургуулиудын хувьд дутмаг байна.

A.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэн ажиллажээ.

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-аас төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтийг тооцон ажиллажээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталсан “Оюунлаг-Булган”, “Морин хуур-Уртын дуу”, “Монгол нум сум” хөтөлбөр, “Соёлын бодлого”-ыг боловсруулан батлуулж мөн “Байгал орчин аялал жуулчлалын газар”-тай хамтран экологийн боловсрол олгох хөтөлбөр батлуулж хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллуулах тухай тогтоол шийдвэр гарган ажилласан нь боловсролын тухай хуулийн 29.1.³, 29.1.1.⁴, 29.1.2.⁵ дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дээрх хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр аймгийн хэмжээнд 2017 онд 75.4, 2018 онд 28.8, 2019 онд 46.0 сая төгрөгийг тус тус зарцуулж ажилласнаар сумдын сургуулийн хамран сургалтын орчин бүрдэж хүүхдүүдийн сурах идэвх чармайлт нэмэгдсэн гэж үзэж байна.

Үүнд: Шатар хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жилийн байдлаар давхардсан тоогоор 4097 сурагчид шатрын дугуйланд хамрагдаж бүх сургуулиуд шатрын дугуйлан болон багш ажиллуулснаар нийт сурагчдын 80 гаруй хувь нь шатар тоглож сурсан үзүүлэлтэй, сурагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан мэтгэлцээн, ой тогтоолт, цаасан урлал зураг, англи хэл гэх зэрэг 80 гаруй дугуйланг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.

Мөн ногоон хөгжил, экологийн боловсрол олгох хөтөлбөрөөр өөрсдийн санаачилгаараа мод тарих, хүлэмж байгуулан сургалтыг амьдралтай холбоход идэвхтэй ажиллаж ихэнх сургуулиуд хүлэмжтэй болж цаашлаад сургуулийн ойр орчимд хоггүй орчин бүрдүүлж ажиллажээ.

- **"Нэг ангид ногдох хүүхдийн тоо зохих түвшинд харилцан адилгүй байна.**

БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 1-ийн нийтлэг үндэслэлийн 4-т заасны дагуу түүвэрт хамрагдсан 13 сургуулийн бага, дунд, ахлах бүлгийн анги дүүргэлт сурагчдын тоо нь зохих түвшинд байгааг харьцуулахад бага дундын бүлгийн ангийн хүүхдийн тоо 35-аас дээш суралцагчтай, зарим сургуулийн анги дүүргэлт 17-20, ахлах бүлгийнх 10 гаруй хүүхэдтэй сургуулиуд байна.

Түүвэрт хамрагдсан сумдын сургуулиудын анги дүүргэлтийг нийт суралцаж байгаа хүүхдийн тооны дунджаар гаргахад бага, дунд, ахлах бүлэгт 17-28 сурагч суралцаж байна.

Бага, дунд, ахлах ангийн дүүргэлт тус бүрээр авч үзэхэд зарим сургуулиудын бага ангийн дүүргэлт хэтэрсэн, зарим сургуулиудын анги дүүргэлт хүрэхгүй байгаа нь харилцан адилгүй байна.

Тухайлбал: 1-р сургуулийн хувьд бага анги 35-40 хүүхэдтэй, Хутаг-Өндөр сумын бага ангийн дүүргэлт 39 хүүхэдтэй, анги дүүргэлт хэтэрсэн, Уньт багийн бага сургуулийн анги дүүргэлт 12-15, Орхон сумын ЕБС дунджаар нэг ангид 17 хүүхэд, Спортын дунд сургуулийн анги дүүргэлт 11 сурагч тус тус суралцаж байгаа нь хангалтгүй үзүүлэлтэй байна.

³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

⁴ боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх,

⁵ орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих

- **Шинээр баригдсан сургуулийн барилгын хүчин чадлыг оновчтой тодорхойлоогүй, барилгын хүчин чадал хүрэлцэхгүй байна.** /2016-2018 онд /

Аймгийн хэмжээнд 2016-2018 онд шинээр сургуулийн барилга баригдсан 2 сургууль, өргөтгөл хийгдсэн нэг сургуулийн барилга ашиглалтад орсон байна.

Үүнд: УТХО-аар аймгийн төвийн 640 хүүхдийн хүчин чадалтай 1, 3-р сургуулийн барилга, Гурванбулаг сумын 240 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилгууд баригдаж ашиглалтад оруулжээ.

Шинээр баригдсан сургуулийн барилгын хүчин чадлыг суралцаж байгаа хүүхдийн тоотой харьцуулахад 1-р сургуулийн хүүхдийн тоо 1404 хүүхэд суралцаж, 2 ээлжээр 640 хүүхдийн, 160 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн байранд, 3-р сургуулийн хувьд 305 хүүхэд 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн байранд тус тус хичээллэн суралцаж байна.

Үүнээс үзэхэд шинээр баригдаж байгаа сургуулийн барилгын хүчин чадлыг оновчгүй тодорхойлж байна.

Иймд шинээр баригдах сургуулийн барилгын хүчин чадлыг суралцаж хүүхдийн бодит тоонд үндэслэн зураг төсвийг оновчтой тодорхойлж саналыг хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл зарим сургуулиуд дээр бүрэн бүрдээгүй байна.

- "Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан ч зарим сургуулиуд зориулалтын бус барилга байгууламжид үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн хэмжээний 22 сургуулиас түүвэрлэлтээр сургуулийн барилга, сурагчдын дотуур байрны барилгуудын ашиглалт, хамгаалалт, орчин нөхцөлийг үзэхэд 13 сургуулиас 3 сургууль нь 2016-2018, 2019 онуудад ашиглалтад орсон шинэ сургуулийн барилгад сургуулийн үйл ажиллагааг явуулж байна.

Аудитад хамрагдсан сургуулиудын ашиглалтад орсон, өргөтгөл хийсэн сургуулийн барилга болон дотуур байрны барилгын он сарыг хүснэгтээр харуулбал:

№	Сумдын сургуулийн нэрс	Сургуулийн барилгын ашиглалтад орсон он сар өдөр	Сургуулийн барилгын өргөтгөл хийсэн он сар өдөр	Сургуулийн барилгын хүчин чадал	Суралцаж байгаа хүүхдийн тоо	Дотуур байрны барилгын ашиглалтад орсон он сар өдөр	Дотуур байрны хүчин чадал, хүүхдийн тоо	Одоо байгаа хүүхдийн тоо, хүчин чадал
1	2-р 10 жилийн сургууль	1964	1992, 1999, 2003	940	1362			
2	Спортын дунд сургууль	1987		120	78		50	40
3	Баян-Агт сумын ЕБС	1976	2011	400	560	1981	80	120
4	Хутаг-Өндөр сумын ЕБС	1977	2020	560	810	1986, 2007	200	230
5	Уньт багийн бага сургууль	1981		Зориулалт биш	68	1981	50	28
6	Орхон сумын ЕБС	1973		320	159	1973	75	48
7	Тэшиг сумын ЕБС	1978		320	657	1979	100	105
8	Сайхан сумын ЕБС	1964		440		1973, 1974, 2003, 2017	190	216
9	Хангал сумын ЕБС	1987		320	145		Зориулалт бус байртай	38
10	Хялганат тосгоны ЕБС	1973	1992, 2003	800	600	2006	60	85

Дээрх хүснэгтээс харахад сургуулийн байр, болон дотуур байрны багтаамж хүрэлцээ муу, зарим сумдын сургууль, дотуур байр нь стандарт бус байранд сургалт явуулж сурагчид амьдарч байна.

Жишээ нь: Уньт багийн бага сургууль нь хуучин баамын барилгад дотуур байр, сургуулийн байр нэг дор, Бугат сумын сургуулийн дотуур байр нь цэцэрлэгийн барилгын нэг хэсэгт, Хутаг-Өндөр сумын сургуулийн дотуур байрыг МХГ-аас 2020 оны 07 сард дүгнэлт гарган 100 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрыг ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар хааж гадуур 70 гаруй хүүхэд байрлаж, нэг байрандаа 160 байрлуулж байна.

Мөн Хангал сумын дотуур байр нь ДЗОУ-ын байгууллага байрлаж байсан барилгыг ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байгаагаас үзэхэд сурагчдын дотуур байрны хүрэлцээ муу, орчин нөхцөл, хүүхдийн аюулгүй байдлын стандартыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Сургуулийн сурагчдын дотуур байрны орчин нөхцөл сайжирсан ч зарим сумдын дотуур байранд 7-8 хүүхэд амьдарч, дотуур байранд амьдрах нөхцөл боломж стандартын дагуу биш, хүүхдийн тооноос шалтгаалан байр хүрэлцэхгүй, засвар үйлчилгээ хийгдэх дотуур байрууд олон байна.

Тухайлбал: Тэшиг, Орхон, Сайхан сум, Хялганат тосгоны сургуулиуд гэхэд эцэг эхчүүд болон төгсөгчдөөсөө хандив авч дотуур байрны тохижилтыг сайжруулсан, мөн ажилчдынхаа хүчээр сургуулийн гадна дотно орчныг сайжруулсан жишээтэй байхад дээр дурдсан сумдын сургуулиудын хувьд дотуур байранд нэг тасагт 7-8 хүүхэд, дотуур байрны орчин нөхцөл стандарт бус орчинд амьдарч байна.

Хангал сумын сурагчдын дотуур байр



Уньт багийн бага сургуулийн байр, дотуур байр



Баян-Агт сумын ЕБС



Цаашид нэн тэргүүнд шаардлагатай дотуур байр болон орчин нөхцөлийг сайжруулах төсөв хөрөнгийг шийдэж өгөх талаар хүсэлт хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

- **Сургуулийн анги танхимыг зориулалтын дагуу ашиглаж байгаа ч БСШУС-дын 2018 оны А/762 тоот тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй байна.**

Аймгийн хэмжээний 22 ЕБС-д хими, физик, математик, монгол хэл, газар зүй гэх зэргээр төрөлжүүлэн бага, дундын кабинетуудыг зохих түвшинд тохижуулан сургалтыг хөтөлбөрийн дагуу хичээллэж байна.

Сургуулиудын тохижуулсан кабинетуудыг үзэхэд зарим кабинет бүрэн тохижсон, зарим нь төсөв санхүүгийн дутагдлаас болж тохижилт бүрэн хийгдээгүй, мөн кабинетын гэрчилгээний хугацаа дууссан сунгаагүй зөрчлүүд илэрсэн ч БСШУСайдын 2018 оны А/762 тоот тушаалын хавсралтаар баталсан “ЕБС-д кабинет, лаборатори байгуулах ашиглах нийтлэг журам”-д кабинет байгуулах саналыг багш, заах аргын нэгдэл эсхүл сургуулийн захиргаа гаргаж болно, түдгэлзүүлэх, татан буулгах шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна гэж зааж өгсөн нь хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт, хяналт сулрах, мөн шаардлага хангахгүй кабинетыг ашиглаж кабинетын нэмэгдэл авах, төсөв хэтрэх зэрэг зөрчлүүд үүсэх магадлалтай байна.

Дээрх БСШУС-ын 2018 оны А/762 тоот тушаалаар баталсан журмын 3.1⁶, 3.2⁷, 3.4.⁸ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, эдгээр шаардлагад нийцүүлэн кабинетын тохижилтыг хийгээгүй, зарим сумд нь кабинетын тоног төхөөрөмж байгаа боловч барилгын дээврээс ус гоождог шалтгаанаас болж ашиглаагүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй анги дотроо гар угаалтуур ашигладаг, гарын авлага, арга зүйн хэрэглэгдэхүүн суралцагчдад хүртээмжтэй биш байна.

Сайхан сумын ЕБС-ийн бага ангийн кабинетууд



Сайхан сум ЕБС-ийн физик анги



Ашиглаагүй тоног төхөөрөмж




Баян-Агт сумын ЕБС-ийн Монгол хэлний кабинет, Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн кабинет



⁶Кабинет, лаборатори нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дүрэм, заавартай байх бөгөөд тэдгээрийг сургалтын менежер хянаж, сургуулийн захирал баталгаажуулна. Дүрэм зааварт кабинет, лаборатори ашиглах, үйл ажиллагаанд баримтлах дэг, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээг тус тус тусгасан байна.

⁷ “Кабинет лабораторид боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, үзүүлэн таниулах материал, урвалж бодис, сурах бичиг, гарын авлага, арга зүйн болон бусад хэрэглэгдэхүүн төвлөрсөн байх бөгөөд тэдгээр нь суралцагчдад хүртээмжтэй байна.

⁸ “Кабинет, лабораторид дараах багц материал заавал байна.



Иймд аймгийн БСУГ-т хариуцуулан шаардлага тавьж, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах талаар журамд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

- **ЕБС-ийн гадаад болон дотоод орчин хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангагдаагүй байна.**

ЕБС-иудын гадна, болон дотоод орчны аюулгүй байдалд анхааран сургуулиа тохижуулан үйл ажиллагаа явуулж байгаа ч Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т тусгагдсаны 3.2.5.4.⁹ заасны дагуу аймаг сумдын ЕБС-иуд сургуулийн гадна үүдний хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, стандартын хэмжээнд заагдсан налуу замыг зарим сургуулиуд сургуулийн гадна хийгээгүй байна.

Аудитад хамрагдсан 13 сургуулиас Тэшиг, Хангал, Сайхан, Орхон сумдын сургуулийн гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж гарах налуу зам хийгдээгүй, мөн налуу зам хийсэн сургуулиуд нь налуу замыг дагуулж төмөр бариулыг хийгээгүй байна.

Цаашид бүх сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдийн аюулгүй орчинг бүрдүүлэхээр налуу зам буюу пандусыг бүрэн хийлгэх шаардлагатай байна.

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БСШУЯ-нд эрх нь шилжсэн УТХО-аар 195.3 сая төгрөгийн тавилга эд хогшил нийлүүлж ажилласан байна.** /шинэ сургуулийн хувьд/

Аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар аймагт эрх шилжиж ирсэн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тавилга, эд хогшил, жилийн төлөвлөгөөнд төлөвлөгдөөгүй байна.

Шинэ сургуулийн хувьд сүүлийн 3 жилээр 1-р сургууль, 3-р сургууль, Бугат сумын ЕБС-ийн барилга шинээр ашиглалтад орж үүнтэй холбоотойгоор улсын болон орон нутгийн төсвөөс тавилга, эд хогшил нийлүүлэгдээгүй, БСШУ-ны яаманд эрх нь шилжсэн УТХО-аар 2017 онд 85.8, 2018 онд 79.8, 2019 онд 29.7 сая төгрөгийн нийт 195.3 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг шинээр баригдсан 3 сургуульд нийлүүлжээ.

- **Сургуульд бэлтгэгдсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ашиглалт хангалтгүй байна.**

ЕБС-иудад түүвэрлэлтийн аргаар аудитад хамрагдсан сургуулиудын лаборатори, кабинетуудын тохижилт, гадна талбай, техник хэрэгслүүдийн хангалт, ашиглалт, хамгаалалтыг үзэхэд бүх сургуулиудын багш нарыг зөөврийн компьютертой болгосон, мөн ухаалаг самбар байршуулсан ч бусад кабинетын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дутмаг байна.

Жишээ нь: ЕБС-ийн орчны аюулгүй байдлын MNS-6782:2019 5.5.2, 5.3, 5.6.1-д заасан тавигдах шаардлагад биеийн тамирын задгай талбайд гүйлтийн зам, гүйлтийн тойрог, гимнастикийн дасгал хөдөлгөөн хийхэд зориулагдсан турник, гар бөмбөг, хөл бөмбөгийн талбайтай, тэдгээр нь хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй нөхцөл бүрдсэн байх гэх боловч сумдын сургуулиуд нь дээрх шаардлагыг хангасан талбай болон техник хэрэгслүүдээр хангагдаагүй байна.

Энэ нь төсөв хөрөнгө батлагдахгүй, хүрэлцээ муугаас шалтгаалж байна гэсэн тайлбарыг өгч байна.

⁹ боловсролын байгууллага нь гадна болон дотно орчноо MNS6055:2009 стандартын дагуу тохижуулах

А.2.3 Сургуулийн захирал, менежерүүд холбогдох шалгуурт нийцэж байгаа ч мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэврийн насны багш нарыг ажиллуулж байна.

• **Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй байна.**

Аймгийн БСУГ-ын гаргасан дутагдалтай багшийн судалгааг жил бүр гаргаж ажиллаж байгаа ч гүйцэтгэлийн аудитаар түүвэрт хамрагдсан 13 сумын сургуулиудын дутагдалтай багшийн тоог гаргахад сүүлийн 3 жилийн байдлаар давтагдсан тоогоор 15 багш байна.

Үүнд: Дуу хөгжмийн багш, хими физик, зураг зүй, эрэгтэй технологийн багш, англи хэл, багийн багш нар дутмаг байна.

Энэ нь алслагдсан сум болон хөдөө орон нутагт залуу боловсон хүчин хот суурин газар ажиллах сонирхолтойгоос шалтгаалж тогтвор суурьшилтай ажиллах багш нар олдохгүй байна гэсэн тайлбарыг өгч байна.

Иймд тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэвэрт гарсан 10 гаруй багш нарыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.

Цаашид хөдөө орон нутагт ажиллах залуу боловсон хүчнийг ажиллуулах тал дээр нийгмийн баталгаа болон амьдрах байраар хангах тал дээр бодлого боловсруулж ажиллах шаардлагатай байна.

• **Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж давхардсан тоогоор 2018 оны байдлаар 3184 багш нарыг хамруулжээ.**

Аймгийн БСУГ нь багшийг хөгжүүлэх хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, график гарган багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт болон, орон нутагт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Сургалтуудыг 2016 оны хичээлийн жилд орон нутагт 578, улсад 158, онлайнаар 57, гадаадад 25 багш мэргэжил дээшлүүлэх сургалтад, 2017 онд багшийг хөгжүүлэх сургалтыг 44 төрлийн сургалтад 2388 багш, 2018 онд 37 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 3184 багш нарыг тус тус хамруулжээ.

Багшийн хөгжлийн тухай хуульд заасны дагуу аймаг сумдын ЕБС-иуд багшийн хөгжлийн төв буюу багш нарын өрөө кабинетыг тохижуулан ажиллаж байгаа ч багшийн хөгжлийн тухай хуулийн 7.3.¹⁰ гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, багш нар бичгийн хэрэглэлийн зүйлсийг өөрсдөөсөө гарган ажиллаж байна.

Энэ нь сургууль бүхэн жилийн төсөвтөө тооцон боловсруулж төлөвлөсөн ч төсөв батлагддаггүй гэсэн тайлбарыг өгч байна.

Цаашид багш нарын бичгийн хэрэглэлийн зардлыг хуулийн дагуу батлуулан ажиллах хэрэгтэй байна.

• **Сургуулийн захирал, эрхлэгч, менежерүүд холбогдох шалгуурт нийцэж байгаа ч зарим сумдын сургуульд мэргэжил тохирохгүй багш нарыг ажиллуулж байна.**

Гүйцэтгэлийн аудитаар нийт 22 сургуулийн буюу 13 ЕБС-ыг аудитад хамруулан үзэж сургуулиудын нийт захирал, менежер багш нарын хувийн хэрэг болон ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтээр нэг бүрчлэн үзэхэд захирал, менежерүүд ажлын байрны шалгуур үзүүлэлтийг хангасан боловч мэргэжил тохирохгүй багш нарыг ажиллуулсан, багш нарын хувийн хэргийн бүрдэлт дутуу, баяжилт хийгдээгүй, ажилд орсон тушаал шийдвэр байхгүй, 5 үеийн намтар дутуу, дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд илэрсэнд албан шаардлага бичлээ.

Мэргэжил тохирохгүй багш ажиллуулж байгаа сургуулиудыг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулийн нэр	Багшийн тоо	Мэргэжил	Орж байгаа хичээл
1	1-р сургууль	1	Бүжигчин	Дуу хөгжмийн багшаар
2	Баян-Агт сумын ЕБС	1	Газар зүй, байгаль шинэчлэл	Биологийн багш
3	Сайхан сумын ЕБС	1	Түүх нийгэм судлалын багш	Бага ангийн багш
4	Сайхан сумын ЕБС	1	Монгол хэл уран зохиолын багш	Бага ангийн багш
5	Тэшиг сумын ЕБС	1	Хими биологийн багш	Иргэний ёс зүйн боловсролын багш

¹⁰ "Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна."

6	Хангал сумын ЕБС	1	Монгол хэл уран зохиолын багш	Бага ангийн багш
---	------------------	---	-------------------------------	------------------

Дээрх хүснэгтээс үзэхэд 5 суманд нийт 6 мэргэжил тохирохгүй багшаар хичээл заалгаж байгаа нь суралцагчдын сурлагын чанарт нөлөөлж уг хичээлийн агуулгыг хүүхдүүд бүрэн дүүрэн эзэмшихгүй эрсдэл үүсэх магадлалтай байна.

- **"Салбарын яам ЕБС-ын хүний нөөцийн бодлого, орон тоог тодорхойлохдоо орон тооны жишиг нормативыг мөрдөж ажиллажээ.**

БШУССайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 тоот "Орон тооны жишиг норматив батлах тухай" тушаалын хавсралтаар баталсан багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативын дагуу орон тоог төлөвлөн баталж ажиллажээ.

ЕБС-ийн багш нарын орон тооны хувьд тухайн жилийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу багшийн нөөц боломжийг гарган тооцоолдог байна.

Аймгийн хэмжээний нийт 22 ЕБС-ийн хүрээнд багш нарын орон тоог тухайн хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөө цагт багтаан тооцон үзэж дутагдалтай багшийн орон тоонд цагийн багш авч хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.

Сүүлийн 3 жилээр ЕБС-д 2016-2017 онд 1095, 2017-2018 онд 1086, 2018-2019 онд 1065 ажилтныг тус тус ажиллуулжээ.

- **БСШУСЯ-ны дээд боловсролын бодлогын газар, мөшгөх судалгаа явуулж байгаагүй, Боловсролын газрын зүгээс багшийн эрэлт, хэрэгцээ, дутагдалтай багшийн судалгааг гарган ажилласан байна.**

Аймгийн БСУГ нь жил бүр дутагдалтай багшийн судалгааг гаргаж жилдээ аймгийн хэмжээнд 40-50 багшийн судалгаа хийгдэж байсан байна.

Өмнөх он буюу 2019 оноос судалгаанд хамрагдсан багш нараас батламж шалгалтыг 2 удаа зохион байгуулж уг шалгалтад нийт 180 гаруй багш нар оролцож үүнээс 51 хувь буюу 92 багш тэнцсэн үзүүлэлтэй байна.

Тэнцсэн багш нараа нөөцөд бүртгэн багш дутагдалтай сумын сургуулиуд нөөцөд бүртгэлтэй багш нараас ажилд авч ажиллуулж байна.

А.3 Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг статистик мэдээний порогнозоор авч бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан боловч сүүлийн жилд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны олголт норматив зардлаасаа илүү зарцуулсан байна.

А.3.1 Төсвийг нийт хүүхэд болон дотуур байр, 1-5 дугаар ангийн хүүхдийн статистик мэдээг үндэслэн төлөвлөж, хүүхдийн тоон үзүүлэлттэй холбогдуулан үр ашигтай хуваарилсан байна.

- **Төрөөс сургуулиудад олгож буй хувьсах зардлыг онцлог, хэв шинжтэй уялдуулан бодитой төлөвлөжээ.**

Ерөнхий боловсролын бага сургууль болон 9 жилийн сургуулиудад 12 жилийн сургуулийг бодвол хувьсах зардлыг¹¹ тогтоол шийдвэрийн итгэлцүүрээр илүү олгосон нь хүүхдийн тоотой шууд хамааралтай гэж үзэж байна.

Хувьсах зардлыг тооцохдоо

- ✓ 1-2 дугаар ангийн хүүхдийг 31 долоо хоногоор
- ✓ 3-5 дугаар ангийн хүүхдийг 32 долоо хоногоор
- ✓ 6-аас дээш ангийн хүүхдийг 33-34 долоо хоногоор үдийн цай 600, дотуур байрны хүүхдийн хоол 2315 төгрөгөөр тооцож олгожээ.

ЕБС-ийн бусад хувьсах зардлыг 100 хувь гэж үзвэл бичиг хэрэг-9.3, шуудан холбоо-18.0, ном хэвлэл-5.5, албан томилолт-8.0, хичээл практик-22.1, нормын хувцас, зөөлөн эдлэл-9.5, эм-1.0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс-10.6, төлбөр хураамж-1.3, бусдаар гүйцэтгүүлэх-9.7, хог хаягдал зайлуулах 5.0 хувиар тус тус тооцож олгосон нь сургуульд суралцаж байгаа хүүхдийн, хэв шинжтэй нь уялдуулан тооцдог байна.

- **Төсвийн хуваарилалт оновчтой, тэгш хүртээмжтэй байна.**

ЕБС-ийн төсвийн хуваарилалтыг тухайн хичээлийн жилд суралцаж буй хүүхдийн тооноос хамааруулж хүртээмжтэй, үйл ажиллагааны зардал, хувьсах зардлын төсвийн төсөөллийг төлөвлөж санхүүжилтийг батлуулан ажиллаж байгааг үзэхэд сүүлийн 3 жилд аймгийн

¹¹ Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын хавсралт болон Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоол

хэмжээнд 2017 онд 16.3, 2018 онд 16.7, 2019 онд 20.2 тэрбум төгрөг буюу нийт 53.2 тэрбум төгрөгийг батлуулж, гүйцэтгэлээр 55.4 тэрбум төгрөг зарцуулсан нь тодотголоор 2.2 тэрбум төгрөгийн тодотголоор нэгтгэгдэж төсвийн хуваарилалт оновчтой, хүртээмжтэй байна.

- **Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.**

Хичээлийн жилийн бүтцийн нийт долоо хоногоос нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг нийлүүлэн нэг долоо хоног байхаар тооцож, Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар 6 настай хүүхдийн тоог 2016-2017 онд 1022, 2017-2018 онд 1587, 2018-2019 онд 1620 буюу нийт 4229 хүүхэд нэгдүгээр ангид элсэн орсноос дотуур байранд амьдрах 6 настай хүүхдийн хичээлийн жилд ногдох зардлыг 462.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөжээ.

Мөн Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолоор дотуур байранд амьдарч, суралцаж байгаа 6 настай хүүхдийн нэг өдрийн хувьсах зардлыг 2315 төгрөгөөр тооцож олгосон байна.

Энэ нь дотуур байрны хүүхдийн хоолны зардал болон хувьсах зардлыг ЗГ-ын тогтоол болон тооцож олгох нормативыг мөрдөж ажиллажээ.

- **Ном, сурах бичигт шаардлагатай хөрөнгийг БСШУСЯ-аас сургуулийн мэдээллийн баазаас татаж төлөвлөсөн байна.**

Түрээсийн сурах бичгийг БСШУСЯ-аас Ерөнхий боловсролын сургуулийн мэдээллийн баазаас татаж Булган аймгийн хэмжээнд 2019 онд 3316 багц ном, сурах бичиг шаардлагатай тоон мэдээлэл гаргаж олгосон байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Сургуулийн нэр	Анги	Хүлээж авсан нийт багцын тоо	Төлбөртэй ашиглуулж буй багцын тоо	Үлдэгдэл багц	Төлбөл зохих төлбөрийн хэмжээ	Төлсөн төлбөрийн хэмжээ	Үлдэгдэл төлбөр
1	Баян-Агт сумын ЕБС	VI-XII	162	29	133	3,109,300	569,200	2,540,100
2	Баяннуур сумын ЕБС	VI-XII	74	21	53	1,470,300	418,200	1,052,100
3	Бугат сумын ЕБС	VI-XII	40	4	36	793,200	76,400	716,800
4	Булган сумын 1-р сургууль	VI-XII	447	61	386	8,360,500	1,181,000	7,179,500
5	Бүрэгхангай сумын ЕБС	VI-XII	110	107	3	2,108,000	2,054,400	53,600
6	Гурванбулаг сумын ЕБС	VI-XII	190	54	136	3,597,400	1,002,600	2,594,800
7	Дашинчилэн сумын ЕБС	VI-XII	183	119	64	3,445,300	2,240,700	1,204,600
8	Могод сумын ЕБС	VI-XII	91	25	66	1,813,800	525,000	1,288,800
9	Орхон сумын ЕБС	VI-XII	34	17	17	663,400	334,200	329,200
10	Рашаант сумын ЕБС	VI-XII	239	60	179	4,562,900	1,167,800	3,395,100
11	Сайхан сумын ЕБС	VI-XII	141	110	31	2,704,300	2,109,300	595,000
12	Спортын дунд сургууль	VI-XII	44	15	29	846,000	288,100	557,900
13	Сэлэнгэ сумын ЕБС	VI-XII	129	86	43	2,425,800	1,680,100	745,700
14	Тэшиг сумын ЕБС	VI-XII	188	56	132	3,594,500	1,066,200	2,528,300
15	Хангал сумын ЕБС	VI-XII	31	2	29	622,300	38,200	584,100
16	Хишиг-Өндөр сумын ЕБС	VI-XII	184	25	159	3,508,600	490,600	3,018,000
17	Хутаг-Өндөр сумын ЕБС	VI-XII	288	72	216	5,435,200	1,318,600	4,116,600
18	Хялганат тосгоны ЕБС	VI-XII	187	60	127	3,554,900	1,161,800	2,393,100
19	Булган сумын ЗӨЦС	VI-XII	409	91	318	7,716,200	1,728,100	5,988,100
20	Булган сумын 3-р сургууль	VI-XII	145	49	96	2,683,200	873,500	1,809,700
ДҮН			3316	1063	2253	63,015,100	20,324,000	42,691,100

Дээрх хүснэгтээс хүлээж авсан 63.02 сая төгрөгийн сурах бичиг 3316 багц, үүнээс төлбөртэй ашиглаж байгаа нь 1063 багцын 20.3 сая төгрөг, 42.7 сая төгрөгийн ашиглаагүй 2253 багц сурах бичгийг 2020 онд сургуулиудад үнэ бууруулж түрээсэлсэн байна.

- **Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсөв дутмаг байна.**

Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын сурах бичгийг төрөөс 100 хувь хангаж дунд бүлэг болон ахлах ангийн сурагчдад түрээсийн сурах бичгийг ашиглуулж сурах бичиг гарын авлага нь тухайн ангийн сургалтын хөтөлбөр, насанд тохирсон хүртээмжтэй байлгахгаар түрээсийн сурах бичгийг ашиглуулсан байна.

Мөн жилийн төсөвт ном хэвлэлийн зардал батлуулж ажилладаг ч шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний зардалд хүрэлцдэггүй байна.

А.3.2 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖИЛИЙН ТӨСӨВ ДУНДЖААР 18 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ТӨСӨВ БАТЛАГДАЖ ТУХАЙН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД АЙМГИЙН САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАЖ БАЙНА.

- **Санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, цаг тухайд нь бүрэн олгосон боловч өмнөх онд гарсан алдаа зөрчлүүд дараа онд давтагдсан байна.**

ЕБС-иудын нэг хүүхдэд ногдох зардлын гүйцэтгэлийг өдөрлөг болон хүнсний материалын зардалтай харьцуулж хүүхэд өдрөөр нь үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тооцсоныг санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар үзэхэд 2017-2019 онд 34.3 сая төгрөгийн илүү олгосон зөрчил илэрсэн байна.

Тухайн зөрчлийг санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар албан шаардлага болон зөвлөмж хүргүүлэн ажилласан ч дараа онд зөрчил дутагдал давтагдсан үзүүлэлтэй байгаа нь төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулжээ.

- **Ном, сурах бичгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

ЕБС-иудын ном сурах бичгийн зардлыг сүүлийн жилийн байдлаар өссөн дүнгээр 23.7 сая төгрөгөөр төсөвлөн батлуулж сургууль тус бүр ном сурах бичгийн зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа ч шаардлагатай ном сурах бичиг худалдан авах зардалд хүрэлцдэггүй гэсэн тайлбарын өгч байна.

Гүйцэтгэлийн аудитаар түүвэрлэлтэд хамрагдсан ЕБС-иудын номын сангийн номын нөөц хангалтыг үзэхэд номын хүрэлцээ дутмаг, ашиглагдахгүй ном ихэнх хувийг эзэлж байгаа нь номын сангийн номын шинэчлэлт хийгдэхээр харагдаж байлаа.

- **Багшийн хөгжлийг дэмжих төсөв хүрэлцдэггүйгээс багш нар өөрсдөөсөө бусад зардлын төсвийг гаргаж байна.**

Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд багш нарыг тухай бүр сургалт, семинарт хамруулж, багшлах эрхийн үнэмлэхийн хугацааг сунгах, мэргэжил дээшлүүлж зэрэг дэв нэмэх, багш сурагч хөгжүүлэх олимпиадад оролцсон амжилт гаргасан багшид дотоод журамд заасан хувь хэмжээгээр болон ур чадварын нэмэгдлийг нэмэлт урамшуулал, хичээл практик, шагнал урамшууллын зардлаас зориулалтын дагуу олгож байгаа боловч багшийн хөгжлийг дэмжих санхүүжилтийг төсөвт суулгаж өгдөггүйгээс бусад зардлуудыг багш нар өөрөөсөө гаргаж байна.

- **Төрийн сан, боловсролын газраас хувьсах зардал олголтод үр нөлөөтэй хяналт тавьж ажиллажээ.**

БСУГ-аас нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг суралцагчийн тооноос хамааруулан нийт хэмжээ нь өөрчлөгдөх зардал юм.

Энэ нь Санхүү төрийн сангийн хэлтэс болон БСУГ-аас хувьсах зардлыг төлөвлөж БСШУСЯ-руу төсвийн төсөөллийг хүргүүлснээр сүүлийн 3 жилийн өссөн дүнгээр төсвийн төсөөллөөр 50.2 тэрбум, тодотголоор 53.3 тэрбум төгрөгийг тодотгож 3.07 тэрбум төгрөг илүү батлагдаж ирсэн байна.

Үүнээс үзэхэд жил бүр хүүхдийн тоо нэмэгдэж, цалингийн шатлал 2018, 2019 онд өөрчлөгдсөн тогтоол шийдвэр, багшийн 5 жилийн нэмэгдэл болон тэтгэвэрт гарах багш

ажилчдын тэтгэмж зэргээс шалтгаалж жил ирэх тусам төсвийн төсөөллөөс илүү батлагдаж ирэх шалтгаан болсон байна.

Аймгийн СТСХ нь жил бүрийн батлагдаж ирсэн төсвийн зарцуулалтад өдөр бүрийн гүйлгээ хийгдэх тутамд хяналт тавьж заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

- **Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож олгосон боловч ЗГ-ын 106 дугаар тогтоолын нормативаас илүү олгосон байна.**

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1, 2, 4 дэх заалт, 3 дахь заалтаар 16 сум, 1 тосгоны бага ангийн сурагч нарт үдийн цайг 600 төгрөгөөр тооцож олгоход норматив зардлаас дунджаар нэг хүүхэд өдрөөр тооцоход 150-280 төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 2315 төгрөгийн норматив зардлаас дунджаар нэг хүүхэд өдрөөр тооцоход 230-290 төгрөгийн хоол цай илүү олгосон нь тухайн үеийн мах, хүнсний материалын үнийн өөрчлөлтөөс үүсэж 2018 онд 32015.0, 2019 оны байдлаар 35809.37 мянган төгрөгийн илүү олгосон зөрчилд тухайн жилийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар албан шаардлага болон зөвлөмж өгч ажиллажээ.

Дотуур байр, үдийн цайны хувьсах зардлын зөрчлийг хүснэгтээр харуулбал: /сая/төг/

№	Сургууль	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Тайлбар
1	Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолыг нэг хүүхдэд 55.04 төгрөг буюу 934.1, үдийн цайн нэг хүүхдэд 13.6 төгрөг буюу 520.8 мянган төгрөгийн материал илүү олгосон	1.5	Албан шаардлага
2	Хишиг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлыг 244.2 төгрөгөөр буюу хүүхэд өдрөөр тооцоход 3901.1, үдийн цай нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлыг 33.5 төгрөгөөр буюу хүүхэд өдрөөр тооцоход 1287.06, нийт 5188.2 мянган төгрөг илүү зарцуулсан байна	5.1	Албан шаардлага
3	Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолны илүү олгосон материал 530.5 мянган төгрөгийн илүү зарцуулсан байна.	0.5	Албан шаардлага

Дотуур байр, үдийн цайны хувьсах зардлын зөрчлийг хүснэгтээр харуулбал: /сая/төг/

№	Сургууль	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Тайлбар
1	Булган сумын 12 жилийн 1-р сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг нэг хүүхдэд ногдох нормативыг 351.4 төгрөг буюу 11775159 төгрөгөөр илүү олгосон байна.	11.8	Зөвлөмж
2	Булган сумын Спортын дунд сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг нэг хүүхдэд ногдох нормативыг 18.5 төгрөг буюу 134252 төгрөгөөр илүү олгосон байна.	0.1	Зөвлөмж
3	Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургууль	Тендер зарлаж шалгарсан "Майдар царам" ХХК хүүхдийн үдийн цайг нийлүүлж сургуулиас 164400 төгрөгийн санхүүжилт илүү олгосон зөрчил илэрлээ.	0.2	Зөвлөмж
4	Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоол материалыг 298,6 мянган төгрөгийг илүү олгосон, сургуулийн хүүхдийн үдийн цай хөтөлбөрийн цайны зардлыг 154.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон.	0.5	Зөвлөмж
5	Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолонд 308.3, үдийн цайнд 252.1 мянган төгрөгийн материал илүү олгосон	0.6	Зөвлөмж
6	Дашинчилэн сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолыг нэг хүүхдэд 94.9 төгрөг буюу 1197.2 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1.2	Зөвлөмж
7	Могод сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг 392.1, Үдийн цай хөтөлбөрийн цайны зардлаас 732.5 мянган төгрөгийн илүү зарцуулсан байна.	1.1	Зөвлөмж
8	Орхон сумын Ерөнхий	Дотуур байрны хүүхдийн хоолны материал, үдийн цайны хүнсний материал нийлүүлэх ААН-ийг сонгон шалгаруулах тендер зарлаагүй	0	Зөвлөмж

	боловсролын сургууль			
9	Рашаант сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолыг нэг хүүхдэд 172.7 төгрөг буюу 4503.4 мянган төгрөгийг илүү олгож, үдийн цайны хүнсний материалыг нэг хүүхдэд 2.6 төгрөг буюу 163.2 мянган төгрөг илүү олгосон байна.	4.7	Зөвлөмж
10	Хангал сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолыг нэг хүүхдэд 632.5 төгрөг буюу 2944.4 мянган төгрөгийг илүү олгож, үдийн цайны хүнсний материалыг нэг хүүхдэд 75.1 төгрөг буюу 891.2 мянган төгрөг илүү олгосон байна.	3.8	Зөвлөмж
11	Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлыг 85.1 төгрөгөөр буюу хүүхэд өдрөөр тооцоход 806675.2, Үдийн цайны материалыг нэг хүүхдэд ногдох цайны материалын зардлыг 2.2 төгрөгөөр буюу хүүхэд өдрөөр тооцоход 33344.3 төгрөг илүү зарцуулсан байна.	0.8	Зөвлөмж
12	Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны хүүхдийн хоолыг нэг хүүхдэд 6.8 төгрөг буюу 98.01 мянган төгрөгийг дутуу олгож, үдийн цайн нэг хүүхдэд 2.54 төгрөг буюу 60.7 мянган төгрөгийн материал илүү олгосон байна. / Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж байгаа тогтоолын дагуу норм нормативаар ажиллах/	0.2	Зөвлөмж
13	Булган сумын Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургууль	Дотуур байрны нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлыг 255 төгрөгөөр буюу хүүхэд өдрөөр тооцоход 2171139 төгрөг илүү зарцуулсан байна.	2.2	Зөвлөмж

Дээрх хүснэгтээс үзэхэд 2018-2019 оны байдлаар 7.1 сая төгрөгийн албан шаардлага, 27.2 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлийн аудитаар дотуур байрны хүүхдийн хоол болон үдийн цайны зардалд дүгнэлт хийхэд Засгийн газраас батлагдсан нормативыг барьж ажиллах, зөрчил дутагдлаа давтахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

- **Гадаадын зээл, тусламжаар нийт 344.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу зарцуулжээ.**

Гадаадын хөрөнгө оруулалтаар Булган аймгийн 12 жилийн “Эрдмийн өргөө цогцолбор” сургуульд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 229.2 сая төгрөгийн санхүүжилт авч сургуулийн их засварыг хийсэн байна.

Мөн Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуульд “Оюунлаг Булган” “Оюунлаг хялганат” хөтөлбөрийн хүрээнд “Канад сан”-гийн хөрөнгө оруулалтаар оюуны спорт Ой тогтоолтын тэнхим, Мэтгэлцээний кабинетыг 11.0 сая төгрөгөөр тохижуулан гадаадын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2019 онд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төсөл бичиж нийт 104.0 сая төгрөгийн санхүүжилтэд хамрагдахаар 8 сургууль шалгарсан байна.

Үүнд:

- ✓ Булган сум 3-р сургууль /Хөгжсөн багшаас чадварлаг сурагч/ 10.9 сая төгрөг
- ✓ Бүрэгхангай сумын ЕБС /Бичгийн соёлтой сургууль/ 10.0 сая төгрөг
- ✓ Хялганат тосгоны ЕБС /Хамтдаа хөгжье/ 13.1 сая төгрөг
- ✓ Могод сумын ЕБС /Дотуур байрны сурагчдын манлайлал/ 16.3 сая төгрөг
- ✓ Тэшиг сумын ЕБС /Эх хэлний өрөө/ 26.3 сая төгрөг
- ✓ Сэлэнгэ сумын ЕБС /Хоцрогдолгүй сурагч ирээдүйн манлайлагч/ 9.9 сая төгрөг
- ✓ Хутаг-Өндөр сумын Хантай багийн бага сургууль /Хөдөө нутгийн судлаач хүүхдүүд/ 6.9 сая төгрөг
- ✓ Хишиг-Өндөр сумын ЕБС /Аргыг нь олбол амжилттай суралцана/ 10.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.

Тус тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжсэнээр сургуулийн суралцах орчин, багш сурагчдын хандлага, сурагчдын хоцрогдол, үндэсний хэл бичгийн соёл, манлайлах ур чадварыг дэмжсэн хөтөлбөрүүд хэрэгжсэн гэж үзэж байна.

- **Сургууль хөгжүүлэх санг байгуулж ажиллаагүй байна.**

“Боловсролын тухай хууль”¹² гэж заасан боловч Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд Сургууль хөгжүүлэх сантай сургууль байхгүй байна.

Сургууль хөгжүүлэх санг байгуулснаар сургуулийн анги танхим, гадаад дотоод орчныг сайжруулах багш ажилчдын үүрэг оролцоо ихсэх сурах орчин болон сурагч, эцэг эхийн хандлага сайжрах тул цаашид сургууль хөгжүүлэх санг байгуулж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа ч багшийн цаг ашиглалт, орлон заах багшийн бүртгэл хангалтгүй байна.

Б.1 Ерөнхий боловсролыг олгох хөтөлбөрт нийцсэн боловсрол олгож сургалтын чанарт үнэлгээ хийгдсэнээр үзэхэд 2018-2019 оны үзүүлэлт өмнөх оноос 8 байраа ахисан үзүүлэлт гарчээ.

Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу төлөвлөж байгаа ч багшийн нөөц боломжоос шалтгаалан хичээлийн хөтөлбөр цаг харилцан адилгүй төлөвлөгдөж байна.

- **Эзэмшвэл зохих боловсрол, ур чадвар, сургалтыг батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч лаборатори сургуулийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөр ижил явагдаж байна.**

БСШУС-ын сайдын тушаалаар баталсан хичээлийн жилийн бүтэц, сургалтын төлөвлөгөөг ахлах, дунд, бага ангид орох хичээлийн жилийн нийт цагийг мэргэжлийн багш тус бүрээр төлөвлөж хуваарь гарган ажилласан ч сургалтын төлөвлөгөө хөтөлбөр “Эрдмийн өргөө цогцолбор” лаборатори ЕБС-ийн хувьд түгээн дэлгэрүүлэлтийн сургалт бусад сургуулиудад явуулдагч сургалтын бүтэц, хөтөлбөр, төлөвлөгөө нь ижил байна.

“Эрдмийн өргөө цогцолбор” лаборатори ЕБС нь 2015-2016 оны хичээлийн түгээн дэлгэрүүлэлтийг 17 төрлийн судлагдахуун буюу бага, дунд, ахлах анги тус бүрээр баг бүрдүүлэн цахимаар болон сумдын сургуулиудад сүүлийн 3 жилийн байдлаар цахимаар нийт 3270 удаа түгээн дэлгэрүүлэлтийн арга зүйн зөвлөгөө, мэргэжлийн чиг баримжаа олгох, сурагчийн төлөвшлийг өөрчлөх, багаар ажиллах, зөвлөн туслах зэрэг сургалтуудыг зохион байгуулж ажилласнаар сумдын сургуулийн багш нар болон сурагчдын хандлагад, арга зүйд, мэргэжлийн, төлөвшлийн өөрчлөлтүүдэд ахиц гарсан гэж дүгнэн, БСШУЯаманд сар, улирал, жилийн эцэст үнэлгээ хийсэн тайлангаа хүргүүлж үр дүнгээ үнэлүүлэн ажиллажээ.

Түүвэрт хамрагдсан сургуулиудын багш нарын 7 хоногт 34 цаг зарцуулах хөтөлбөр, төлөвлөгөө, багшийн цаг ашиглалт, нэгж хичээлийн цагийн төлөвлөгөө, орлон заасан багшийн бүртгэл, ажлын үнэлэлт дүгнэлтийг шалгуур үзүүлэлтээр нь дүгнэсэн байдлыг үзэхэд багш нар бусад 15 цагт зарцуулах цагийн төлөвлөгөөг төлөвлөж ажилладаггүй, чөлөөтэй, өвчтэй, тасалсан багшийг бүртгэсэн боловч сарын эцсийн нэгтгэл цагийн бүртгэлд бүтэн ажилласнаар, мөн өвчтэй чөлөөтэй тасалсан багшийн хоногийг хассан боловч цалинг бүтэн олгосон, чөлөөний хуудас, өргөдөл, өвчний магадалгааг нотлох анхан шатны баримт дутуу, архивын баримт болгоогүй, сургуулийн дотоод журмыг мөрдөж ажиллаагүй нийт 4870.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Цаашид ЕБС болон лаборатори сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг бүрэн төлөвлөн батлуулж ажиллах, багш нарын цаг ашиглалтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв хөтөлж архивын нэгж болгон ажиллах шаардлагатай байна.

- **Нэмэлт сурах бичиг, гарын авлагыг жилд нийт 340 гаруй сурах бичгийг нэмэлтээр ашиглаж байна.**

Аймгийн хэмжээний ЕБС-иуд бага, дунд ахлах ангиудад нийт 17 судлагдахуунаар хичээл орж нэмэлт сурах бичиг жилд 1 судлагдахуунд 5-20 төрлийн нийт 340 гаруй төрлийн сурах бичгийг нэмэлтээр ашиглаж байна.

¹² 39.11. “Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална

Салбарын яамнаас баталсан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу судалж үзэх ном сурах бичгийг түрээсээр ашиглаж байгаа ч тухайн хичээлд шаардагдаж байгаа сурах бичиг, гарын авлагыг нэмэлтээр үзэж сургалтаа явуулж байгаа нь 1-р ангийн хүүхэд буюу 6 насны хүүхдийн цүнхний жинд нөлөөлж байгааг эцэг эх болоод сургуулийн зүгээс хяналт тавьж ажиллах шаардлага үүсэж байна.

Энэ нь эрүүл мэндийн төв болон эмчийн зөвлөсөнөөр бага насны болон бага ангийн хүүхдийн үүрэх ёстой цүнхний жин нь хүүхдийн биеийн жингийн 10 хувиас хэтрэхгүй жинтэй байх стандартыг баримталж ажиллах нь зүйтэй байна.

- Олон улсын сургалттай сургуулийн сургалтын хөтөлбөрийг БСШУСЯ, АНЗД хянаж, баталсан уу? /мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, хувийн сургууль/ Хамааралгүй.

Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарт үнэлгээг үнэлж дүгнэн ажилладаг ч нийт амжилтаас харахад сурлагын чанарын үнэлгээний хувь 2018-2019 онд өссөн үзүүлэлтэй байна.

- ЕБ-ын чанарын үнэлгээний судалгааг сурагчдын улирал болон ЕШ-ын дүнгээр үзүүлэлт гарган дүгнэн ажиллажээ.**

Аймгийн хэмжээндэх 22 ЕБС нь хичээлийн жилийн суралцагчдын сурлагын чанрын үнэлгээг улирлаар болон ЕШ-ын дүнгээр тус бүр гарган үнэлж ажилладаг байна.

БСУГ нь жил бүрийн Ерөнхий шалгалтын нэгдсэн дүнгээр сургалтын чанарт үнэлэлт дүгнэлт өгч цаашид анхаарах асуудлыг шат шатанд нь зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан ч сүүлийн 3 жилийн байдлаар ЕШ-ын оноо үзүүлэлт, сурлагын ахиц харилцан адилгүй гарсан байна.

Он оны ЭШ-ын дүн болон үнэлгээг хүснэгтээр харуулбал:



Дээрх хүснэгтээс үзэхэд сүүлийн 3 жилийн ЕШ-ийн дүнгээс улсын дундаж оноо, аймгийн дундаж оноо, эзэлсэн байр зэргийг харьцуулан харахад авах онооны үзүүлэлт 2016-2017 онд авсан онооноос 2017-2018 онд амжилт үзүүлсэн оноо буурсан, 2018-2019 онд өсөж улсын хэмжээнд байр эзлэлт 8 байраар ахисан байна.

- "Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бодитой үнэлж ажилласан ч сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр багш нараас авсан шалгалтын үнэлгээ хувь буурсан үзүүлэлтэй байна.**

БСУГ нь жил бүр сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг багш нараас онолын шалгалт болон сурагчдын явц, улирлын шалгалтын дүнг үнэлж дүгнэн багшийн туршлага, ур чадвар, менежерийн арга барил, суралцагчдын идэвхи, суурь хүмүүжил, багш нарын хандлагын өөрчлөлт, башийг тогтвор сууршилтай ажиллуулах зэрэгт анхаарч ажиллах нь зүйтэй гэж дүгнэн тодорхойлсон байна.

ЕБС-иудад хийсэн үнэлгээнээс цаашид анхаарч ажиллах тал дээр жил бүр багш нарыг сургалтанд хамруулж сүүлийн 3 жилийн багш нараас гарааны, ахицын болоод онол мэргэжлийн шалгалт авсан дүнгээс харахад 2016-2017 онд 14.5, 2017-2018 онд 4.7, 2018-

2019 онд 2.4 хувийн үзүүлэлтэй гарсан нь өмнөх онуудын шалгалтын үзүүлэлтийн хувь буурсан үзүүлэлтэй гарчээ.

Үүнээс дүгнэн үзэхэд зарим жил ахиц гарсан ч сүүлийн 2 жил шалгалтын дүн буурсан нь багш нарын мэдлэг чадварт ахиц гараагүй байгаа нь сургалтын чанар болоод багш нарын мэдлэг, урч чадвар сул гэж дүгнэж байна.

Цаашид багш нарт өгч байгаа сургалтыг чанаржуулах, багш нарын мэдлэг, чадвар, хандлагыг нэмэгдүүлэх, сургалтыг чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй явуулах шаардлагатай байна.

Б.2. Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг 16 сум 1 тосгоны хэмжээнд дотоод хяналтын баг томилж ажиллуулж байгаа боловч зарим сумын сургуулиудад хийгдсэн дотоод хяналт үр дүн муу байна.

• **Б.2.1. Салбарын яамны хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна.**

Боловсролын үнэлгээний төв нь жил бүр 5-9 дүгээр ангийг түүвэрт хамруулж мөн Улсын ерөнхий шалгалтын үед чанарын үнэлгээ хийж, гарч байгаа алдаа зөрчил дутагдалд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мөн удирдах ажилтан, багш, СӨБ-ын тогооч, нярав нарт жилдээ 23-41 төрлийн сургалтыг Оюутны холбоо, Боловсролын хүрээлэн, ММНББИ зэрэг олон байгууллагатай хамтарч хийж аймгийн хэмжээнд давхардсан дүнгээр сүүлийн 3 жилд 4.0-7.0 мянган багш ажилчдыг хамруулж БСШУСЯамнаас “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” хөтөлбөр хэрэгжиж Азийн хөгжлийн банк, БСШУСЯ хамтарч 166.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээр сургуулийн сургалтын чанар, ажиллах сурах орчин, тоног төхөөрөмж сайжирсан гэж үзэж байна.

Боловсролын хүрээлэн, БСШУСЯамнаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар онлайнаар хяналт тавьж ажилласанаар хөтөлбөрийн үр дүнд гарах өөрчлөлтийг багшийн заах арга, сурагчдын сурлагын үзүүлэлт зэргээр хяналт тавьж ажиллажээ.

• **Салбарын яамны зүгээс гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож ажиллажээ.**

Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 10 сургууль гадаадын зээл, тусламжаар 344.2 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт хамрагдан сургуулийнхаа их засвар болон тохижилт үйлчилгээг сайжруулан ажилласан байна.

Тухайн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд шат шатны хяналт тавьж тус хөтөлбөр төсөлд хамрагдсанаар сургуулийн гадаад, дотоод орчин, хүүхдийн сурах нөхцөл боломж сайжирч үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэжээ.

• **Орон нутгийн боловсролын газрын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа боловч алдаа зөрчил нь давтан гарсаар байна.**

БСУГ-аас 16 сум 1 тосгоны хэмжээнд жилд нэг удаа буюу 2017-2019 онуудад 6 удаагийн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг БСШУСЯамнаас ирсэн чиглэл болон дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Он оны СТА болон мэргэжлийн байгууллагын хяналтын дүгнэлтээр гарсан зөрчил дутагдалыг ариулгуулах арга хэмжээг тухай бүрт нь авч ажиллаж байгаа боловч давтан гарсаар байна.

• **БСУГ дотоод хяналт хийх багийн гишүүдийг байгууллагын даргын тушаалаар тухай бүр нь томилон ажиллуусан ч дотоод хяналт сул гэж дүгнэлээ.**

Аймгийн БСУГ нь дотоод хяналтын баг байхгүй тухай бүр нь баг бүрэлдэхүүнийг даргын тушаалаар томилож жил бүр СӨБ, ЕБС-дад дотоод хяналт хийж сурлагын үзүүлэлт, сургалтын үйл ажиллагаа, бодлого зохицуулалт, арга зүй, гарсан алдаа дутагдал, хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах зүйлсийг арга зүйгээр хангаж ажиллажээ.

Түүвэрт хамрагдсан сургуулиудаас илэрсэн зөрчлүүдийг авч үзвэл багшийн ур чадвар, суралцагчдын сурлагын үзүүлэлт, багш нарын цаг ашиглалт, архив бичиг хэргийн мөрдөлт зэрэгт тавих шат шатны хяналт сул байна.

• **Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцоогүй байна.**

Боловсролын хүрээлэн, БСШУСЯамнаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар онлайнаар хяналт тавьж ажилласанаар хөтөлбөрийн үр дүнд гарах

өөрчлөлтийг багшийн заах арга, сурагчдын сурлагын үзүүлэлт зэргээр үр дүнг тооцон ажилалсан гэх боловч Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн 104.0 сая төгрөгийн тэтгэлгт хөтөлбөрт хамрагдсан 8 сумын сургуулиудын хэргэлтэнд хяналт тавьж ажилласан тайлан мэдээ байхгүй, хяналт хийгдэж ажиллаагүй байна.

- **Салбарын яамнаас багш бэлтгэж буй их дээд сургуулийн хөтөлбөр, чанрын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан ч зарим төсөл хөтөлбөрт хяналт хийсэн тайлан мэдээ байхгүй байна.**

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт 2018-2019 онд багшлах эрх 5, 10 дахь жилийн сургалтанд хамрагдсан 2247 багшийн эрхийг сунгаж ажилласнаас аймгийн хэмжээнд 17 багш багшлах эрхийн үнэмлэхээ сунгаж, 2017-2018 онд мэргэжлийн болон мэргэжлийн бус 5095 багшийн магадлан итгэмжлэгдсэн сургууль, сургалтад хамруулж мэргэжил дээшлүүлсэн ажиллажээ.

Боловсролын хүрээлэн, БСШУСЯамнаас “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” хөтөлбөр хэрэгжиж төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд онлайнаар хяналт тавьж ажилласнаар хөтөлбөрийн үр дүнд гарах өөрчлөлтийг багшийн заах арга, сурагчдын сурлагын үзүүлэлт зэргээр үнэлж хангалттай үнэлгээ өгч ажилласан боловч 2019 онд БСШУСЯ-аас зохион байгуулж байгаа тэтгэлэгт хөтөлбөр нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрт төсөл бичиж сонгогдсон 8 сумны ЕБС-д 104.0 сая төгрөг тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтэд БСШУСЯ, Азийн хөгжлийн банкнаас 2019 оны эцэст хяналт тавьж ажиллахаар төлөвлөж байсан боловч тэтгэлэгт хөтөлбөрийн үр дүнд хяналт тавьж ажиллаагүй зөрчилд албан шаардлага бичлээ.

- **Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй ажилласан байна.**

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг Монгол Улсын БСШУС 2015 оны А/220 дугаар тушаал, 2017 оны А/61 дүгээр тушаал, 2018 оны А/453 дугаар тушаалаар баталж хавсралтаар бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг баталсанаар сургуулийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрт захирал, менежер хяналт тавьж багш нарын сургалтын хуваарь, анги танхим дүүргэлт муу байгаагаас ажил таслалт, анги цонхлох зэргээс шалтгаалан хүүхдийн сурлагын түвшин, чанарын үзүүлэлт буурч байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн 7 хоногийн 19 цаг, багш зохицуулах 15 цагийн хичээлийн хуваарийн дагуу орж байгааг жижүүр багшийн бүртгэлээр сүүлийн 3 жилийн хичээлийн жилийн бүртгэлийг үзэхэд багшийн ирцийн бүртгэл хангалтгүй байна.

Бүх нийтийн боловсролын байгууллагын менежерийн удирдах чадвар, багшийн цаг ашиглалт, анги танхимын дүүргэлт хангалтгүй, сургалтын төлөвлөгөө ойр ойрхон солигдож байгаагаас шалтгаалж сургалтын чанарын үзүүлэлтэд нөлөөлж болзошгүй байна.

Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллажээ..

- **Мэргэжлийн байгууллагуулын зүгээс жилд сургуулиудад түүвэрлэлтийн аргаар хяналт шалгалтыг хийсэн байна.**

Аймгийн мэргэжлийн хяналтын газар нь боловсролын байгууллагад жил бүр төлөвлөгөөт шалгалтыг түүвэрлэлтийн аргаар сүүлийн 3 жилийн байдлаар сургуулиудын үйл ажиллагаанд шалгалт хийхэд сургуулиудын барилга байгууламж стандартын бус, шаардлага стандартад нийцэхгүй, эрсдэлтэй үнэлгэдсэн, гадна, дотоод орчний хүүхдийн аюулгүй байдал, эрүүл орчин хангалтгүй үзүүлэлтэй гарч байгаа зөрчлүүдэд тухай бүр нь заавар зөвлөгөө, албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж албан шаардлагын биелэлт, алдаа зөрчлүүд жил жилээс жилд багассан ч 100 хувиар биелэгдэхгүй байгаа нь сургуулиудын төсөв хөрөнгийг шаардлагын дагуу батлаж өгдөггүй, орон нутгаас төсөв хөрөнгийн дэмжлэг үзүүлэх туслалцаа дутмаг гэж дүгнэгдсэн байна.


- **Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс үзэхэд эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт 2019 оноос сайжирсан гэж дүгнэгдлээ.**

ЕБС-иудад суралцаж байгаа сураглцагчийн эцэг эх, асран хамаагачийн зүгээс тавих хяналтыг эцэг эх, багш, цагдаагийн байгууллагатай хамтран гурвалсан гэрээ байгуулж

гараас гарт гэсэн үйл ажиллагаа зохион байгуулж ажилласнаар сүүлийн жилүүдэд судалгаагаар үзэхэд хүүхэд тавих эцэг эх, олон нийтийн хяналт сайжирсан үзүүлэлтэй гарсан байна.

Тухайлбал: Эцэг эхчүүдийг хамруулсан хуулийн болоод үүрэг хариуцлагын сургалт болон бусад сургуулийн үйл ажиллагаанд хамтран ажилласнаар үүрэг хариуцлага нь нэмэгдэж хяналт сайжирсан гэж дүгнэж байна.

Эцэг эх, асран хамгаалалын хяналтын судалгааг хүснэгтээр харуулбал:



Дээрх хүснэгтээс харахад эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ харилцах харилцаа болон асуумжийн 6 үзүүлэлтийг авч үзэхэд хүүхдийнхээ хүсэл сонирхол хэрэгцээ шаардлагыг хамгийн түрүүнд сонсох шаардлагатай гэсэн үзүүлэлт гарсан байна.

Аудитаар нийт 4.8 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, дотоод ажил сайжруулахаар 104.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмжийг тус тус бичлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- ЕБС-иудын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, норм норматив хэрэгцээ шаардлагыг хангасан, харилцан уялдаатай байгаа ч зарим нэг хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна.
- Эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, саналд тулгуурлан шинэчлэн баталж байгаа ч сургалтын хичээлийн хөтөлбөрийг жил бүр шинэчилж байгаа нь сурлагын чанарын үзүүлэлтэд нөлөөлж үр дүн багатай хэрэгжиж байна.
- Сургалтын хичээлийн хөтөлбөрийг тогтвортой барих бодлого хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.
- Эзэмшвэл зохих боловсрол, ур чадвар, сургалтыг батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа ч лаборатори сургуулийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөр ижил явагдаж байна.
- Орон нутгийн салбар нэгжээс багш болон мэргэжилтнээс хяналт шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулдаггүй байна.
- Сургуулийн захирал, менежерүүд холбогдох шалгуурт нийцэж байгаа ч мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэврийн насны багш нарыг мөн мэргэжил тохирохгүй багш нарыг ажиллуулсан байна.
- Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин, материаллаг орчин дутмаг байна.
- Багш нарын цаг ашиглалт, ирцийн бүртгэл, хөтлөлт хангалтгүй, чөлөөтэй өвчтэй, тасалсан багшийн анхан шатны баримтыг бүрдүүлж ажилладаггүй, цалинг бүтэн олгосон мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.
- Багш нарын хувийн хэргийн бүрдэлт дутуу, баяжилт хийгддэггүй, багш нарын цагийг сургууль бүр өөр цагийн бүртгэлээр хөтөлсөн, орлон заасан багшийн бүртгэл хөтөлдөггүй зэрэг зөрчилд албан шаардлага бичлээ.

- Шинээр баригдсан сургуулийн барилгын хүчин чадлыг оновчтой тодорхойлоогүй, барилгын хүчин чадал хүрэлцэхгүй байна.
- Зориулалт бус барилга байгууламж ашиглан дотуур байранд нэг тасагт 7-8 хүүхдийг байрлуулж байна. /2-3 сургуулийн хүрээнд/
- Кабинетуудыг зохих түвшинд тохижуулан сургалтыг хөтөлбөрийн дагуу хичээллэж байгаа боловч БСШУС-дын 2018 оны А/762 тоот тушаалаар баталсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг статистик мэдээний порогнозоор авч бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан боловч сүүлийн жилд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны олголт норматив зардлаасаа илүү зарцуулалт хийгджээ.
- Гадаадын зээл, тусламжаар нийт 344.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу зарцуулсан гэх боловч Азийн хөгжлийн банкны санхүүжилтээс хэрэгжсэн тэтгэлэгт хөтөлбөр 104.0 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.
- Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр багш нараас авсан шалгалтын үнэлгээ хувь буурсан үзүүлэлтэй байна.
- Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг 16 сум 1 тосгоны хэмжээнд дотоод хяналтын баг томилж ажиллуулж байгаа боловч зарим сумын сургуулиудад хийгдсэн дотоод хяналт үр дүн муу байна.
- Мэргэжлийн байгууллагуулын зүгээс жилд сургуулиудад түүвэрлэлтийн аргаар хяналт шалгалтыг хийж заавар зөвлөгөө, албан шаардлага хүргүүлж ажилладаг ч хэрэгжилт 10 хувиар биелэгдэггүй нь төсөв хөрөнгийн асуудалтай холбон үзэж байна.
- ЕБС-иудын хичээл практикийн бичиг хэргийн, тоног төхөөрөмжийн зардлуудыг хүртээмжтэй баталж өгдөггүйгээс сургалтын орчин нөхцөл стандартын дагуу анги тохижилт хангагдахгүй, сургуулийн гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон гарах шат хийгдээгүй байна.
- Багш нарын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах орон байрны хангалт байхгүйгээс багшийн хүрэлцээ дутмаг, багш дутагдаж байгаа шалтгаан болж байна.
- ЕБС-иудын үйл ажиллагаагаа сүүлийн 3 жилд сайжирч УТХО хөрөнгө оруулалтаар барилга байгууламж шийдэгдэж байгаа ч аймаг сумын орон нутгийн хөрөнгө оруулалтад төсөв суугдаж ажиллаагүй нь боловсролын байгууллага руу чиглэсэн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт хангалтгүй, цогцоор нь шийдэх бодлого төлөвлөх шаардлага үүссэн байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг: Аймгийн Засаг даргад

- ЕБС-иудын зориулалт бусаар ашиглаж байгаа дотуур байрны барилга байгууламжийн төсөв хөрөнгийг нэн тэргүүнд шийдэж өгөх
- ЕБС-иудын кабинетуудыг БСШУС-дын 2018 оны А/762 тоот тушаалаар баталсан журамд заагдсан тавигдах шаардлагын дагуу тохижуулах төсөв хөрөнгийг шат дарааллаар нь баталж ажиллах.
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт жил бүр дутагдаж байгаа тоног төхөөрөмжийн төсвийг төлөвлөн батлуулж ажиллах.

Хоёр: Айгийн БСУГ-ын даргад

- Мэргэжил тохирохгүй багш нар ажиллуулахгүй тал дээр анхаарч ажиллах.
- Дотоод хяналтын баг байгуулж сургуулиудын дотоод хяналтын багт зөвлөмж зөвлөгөө өгч ажиллах.
- Орон нутгаас явуулж байгаа сургалтын чанарыг сайжруулж ажиллах.
- Сургуулиудын менежерийн дотоод үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.
- Гадаадын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан хэрэгжилтийн үр дүнг тооцон ажиллаж байх.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

П.МӨНХТУЯА
Б.ЭНХТӨР

Холбогдох байгууллагын санал:

	 БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРТЭДЭХ БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант Утас: 7034-2723, E-mail: bulgan@mees.gov.mn <u>2020. 10. 30</u> № <u>1/2026</u> танай _____ -ны № _____ -т БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Монгол улсын Ерөнхий аудиторын "Аудитын сэдэв батлах тухай" 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно. ДАРГА  Э.ТУВШИНМӨНХ D /jijig blanc/
	 БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг Цогт Хүн Тайзангын талбай, Утас: 7034-2938, Факс: 7034-2250 http://www.Bulgan.gov.mn <u>2020. 10. 30</u> № <u>03/1082</u> танай _____ -ны № _____ -т АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Төрөөс бүх нийтэд ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд санал байхгүй болно. ДАРГА  О.НАРАНЖАРГАЛ 20192145

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 8/24

Булган

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаал, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг үндэслэн “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Засаг дарга болон Боловсрол Соёл
Урлагийн газарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга болон Боловсрол Соёл Урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцордол/-д даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудиторт /П.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

006019082

D: /bnchig hereo/2020/tushaal/TAtushaal.doc